

**УУРЛАХ ХИЛЭГНЭХ ҮЙЛДЛЭЭР УРАН ДҮРИЙГ ТОДРУУЛАХ НЬ
(Ч.Лодойдамбын “Тунгалаг Тамир” романы баатруудын жишээгээр)**

Д.Отгонцэцэг

Энэхүү өгүүлэл нь орчин цагийн монгол хэлний хэлэхүйн үйлдлийн нэлээд идэвхтэй, харьцангуй бүтээлч шинжтэй хэв маяг болох инээх инээмсэглэх болон уйлах уярах үйлдлийг монгол хэлэнд илэрхийлэх үгэн ба үгэн бус арга хэрэглүүрийн хэв шинжийг тусгайлан сонирхож саяхнаас шинээр эхлүүлсэн бидний өмнөх ажиглалт судалгааны ажлын нэгэн үргэлжлэл (Отгонцэцэг Д. 2014; 2015; 2016; 2017; 2019) болох юм. Бид энэ удаа монгол хэлний энэхүү инээх инээмсэглэх болон уйлах уярах үйлдлийн эсрэг хэв шинж болох уурлах хилэгнэх¹ үйлдэл заасан үйл үгийн үүрэг-утга зүйн онцлогийг Ч.Лодойдамбын “Тунгалаг Тамир” романы баатруудын хэв шинжит дүрийн жишээгээр тусгайлан судалж тодорхой ажиглалт хийхийг гол зорилго болгосон билээ. Мөн баатрын сэтгэлийн байдал, сэтгэлийн хөдөлгөөний олон хэлбэрийн дотроос хамгийн их давтамжтай, харьцангуй бүтээлч шинжтэй “инээх инээмсэглэх” – “уурлах хилэгнэх” – “уйлах уярах” гэсэн энэ гурван үйлдлийг бүртгэн тооцоолж өөр хоорондынх нь харьцаа хамаарлыг олж тогтоохыг оролдов. Ингэхдээ зөвхөн “инээх”, “уйлах”, “уурлах” утгат үйл үгийн төрөл үгийн хүрээнд хязгаарлан үгийн олонлог үүсгэж үзсэн болно. Өөрөөр хэлбэл, “уурлах” утгат үгийн хувьд уурлах, уурсах, хилэгнэх, бухимдах, цухалдах гэх мэтийн хэлбэрээр нь төлөөлүүлэн оруулсан гэсэн үг юм.

Бид өмнөх цуврал судалгаандаа уг романы баатруудын инээх инээмсэглэх болон уйлах уярах үйлдлийг явцуу хүрээнд хязгаарлан тухайн дүрийн хэв шинжит онцлог, бусдаас ялгарах өвөрмөц байдал, зохиолын үйл явдлын өрнөл, явц болоод тодорхой учир холбогдолтой байж болох тийм тохиолдлуудыг л бүртгэн авч ажиглалт хийсэн билээ.

Энэ удаагийн судалгаандаа ажиглалтын хүрээ, ажиглалтад хамруулах зохиолын баатруудын тоог өргөтгөн нэр нь олон дахин дурдагдаж зохиолын үйл явдалд идэвхтэй оролцдог нийт 40 гаруй² дүр, нэр нь дурдагдсан ч зохиолын үйл явдалд төдийлөн идэвхтэй оролцдоггүй дүр, бас нэр нь тодорхой дурдагдаагүй дүр буюу лам багш, данжаад, шушмаа,

¹ “Гучин зургаат тайлбар толь”-ийн 13-р дэвтрийн “Хүний хураангуй”-н 6468-6503 дахь тоон дугаарт “инээх инээмсэглэх зүйл”, 6779-6805 дахь тоон дугаарт “уйлах уярах зүйл” (Сумьяабаатар Б. 2003:44, 46) хэмээн “инээх”, “инээмсэглэх” болон “уйлах”, “уярах” үйл үгийг ойролцоо утгат үйлийн хоршоо үг болгож хошоодоор нь гарчиглан оруулсны дагуу мөн дэвтрийн мөн хураангуйн 6806-6854 дэх тоон дугаарт “хилэгнэх уурлах зүйл” (Сумьяабаатар Б. 2003:47) гэж тодорхойлсныг энд бас эш үндэс болгож байна.

² Энэхүү романы дүрийн тооны талаар утга зохиол судлаач, доктор Б.Ганбат бичихдээ “Миний хувьд урьд нь энэ романы дүрүүдээс зүгээр нэг нэр орсон төдийг нь орхин тоолж 70 орчим дүртэй хэмээн тооцоолж байсан юм. Энэхүү нэгэн сэдэвт зохиолыг бичих үест юу боловч нэрлэн бичсэн хүмүүсийг тооцоолж үзвэл 110 гаруй болов. Яг ийм зарчмаар тооцоолбол “Үүрийн туяа”-д 140 гаруй, “Цаг төрийн үймээн”-д 50 гаруй дүр байна. Харин романы өгүүлэмжид тодорхой байр эзлэн, үйл явдалд идэвхтэй оролцсон, үзэл бодол, зан чанар нь ялгарсан, бидний энгүүн ярьдгаар “амьд хүн мэт” болсон дүр гэвэл “Тунгалаг Тамир” романы Эрдэнэ, Төмөр, Долгор, Баг, Итгэлт, Должин, Солонго, Дулмаа, Галсан, Ням, Сүрэн, Бадарч, Довчин, Гэрэл, Хуяг, Магсаржав, Дорж, Өлзий, Цэнд, Пүрэв, Цамба, Жамбал, Чимэг, Цэцэг, Түгжил, Павлов, Петр, Жаргал, Эрэнчин, Сүхбаатар, Баяр, Дэжид, Жадамбаа, Дамбадорж, Данзан нарын 35 дүр байна” (1998:245) гэжээ. Гэвч сайтар ажиглан бүртгэж үзвэл энд Хонгор, Даржаа, Ванданов нарын нэр дурдагдаагүй бөгөөд бас нэлээд хэдэн дүр орхигдсон тал байна.

цэрэг гэх мэтийн хүмүүсийн сэтгэлийн хөдөлгөөний дурдсан гурван үйлдлийг нэг бүрчлэн шавхан бүртгэж гаргахыг хичээсэн болно.

Ажиглалтаас үзвэл, инээх, уйлах, уурлах гэсэн энэ гурван үйлдэл нь өөр хоорондоо холбоотой, бас эсрэг тэсрэг шинжтэй, харилцан сүлжилдэн холбогдсон байдалтай гэж ойлгож болохоор байна.

Романд инээх инээмсэглэх, уйлах уярах, уурлах хилэгнэх үйлдэл нь гурвуулаа, эсвэл хоёулаа, аль эсвэл зөвхөн ганцаараа дурдагдсан баатруудыг дотор нь дараах байдлаар бүлэглэн үзэж болох юм. Үүнд:

а/ Нэр нь байнга дурдагдаж зохиолын үйл явдалд идэвхтэй оролцдог;

б/ Нэр нь хааяа дурдагддаг ч зохиолын үйл явдалд төдийлөн идэвхтэй оролцдоггүй;

в/ Нэрээрээ дурдагдаагүй ч зохиолын үйл явдалд хаа нэг ямар нэгэн байдлаар оролцсон;

Монгол хэлний “уурлах” төвт үйл үгийн утга зүйн оронд уурлах, уурсах, хилэгнэх, хилэнлэх, цухалдах, бухимдах зэрэг үйл үг багтдаг байна.

Монгол хэлний тайлбар толь бичгүүдэд уурлах гэдэг үгийг “1. хилэгнэх, уур хүрэх, цухалдах, 2. *хуучирсан* дотроо муу санах” (Цэвэл Я. 1966:606б), “1. Хэрэг явдалд дургүйцсэнээс муу үг хэлж, цухалдах, хилэгнэх, 2. *хуучирсан* Дотроо муу санах” (Болд Л. 2008:2260аб), “1. хилэгнэх, цухалдах; уур нь хүрэх” (Дамбажав И. 2010:443), “1. хилэгнэх, уур хүрэх, цухалдах” (Цэвэл Я. 2013:835а), “1. уур хөдлөх, ууртай сэтгэгдлээ ил гаргах, 2. дотроо муу санах, муухайгаар бодох” (Одонтөр Ш., Баттөгс М. 2013:II. 689в-690а) гэх зэргээр, уур гэдэг үгийг “хилэн, ихэд дургүйцэж хорсох байдал” (Цэвэл Я. 1966:606а), “хилэн, ихэд дургүйцэн хорсох байдал” (Болд Л. 2008:2258б), “дургүйцлээ илэрхийлсэн догшин ааш хилэн” (Дамбажав И. 2010:442), “хилэн, ихэд дургүйцэж хорсох байдал” (Цэвэл Я. 2013:834б), “бусдын үйлдэл, үг яриа санаанд тохирохгүй үед эсэргүүцлээ илэрхийлэх сэтгэл хөдлөлийн хүчтэй хувирал” (Одонтөр Ш., Баттөгс М. 2013:II. 689а) гэх мэтээр тус тус тайлбарласан байна.

“Тунгалаг Тамир” романы дөчөөд баатар үйл хөдлөл, үзэл бодол, үг яриагаараа төдийгүй сэтгэлийн байдал, сэтгэл хөдлөлийн янз бүрийн илрэл болох инээх инээмсэглэх, уйлах уярах, уурлах хилэгнэх үйлдлээрээ бас өөр хоорондоо ялгаран хэв шинжит уран дүрийг дор бүрнээ тус тусдаа цогцлоон бүтээсэн байдаг байна. Романд дүрслэгдсэн дөч гаруй баатруудын дотроос уурлах үйлдэл нь нэгээс дээш бүртгэгдсэн 18 хүн байгаа бөгөөд тэднийг уурлах үйлдлийнх нь давтамжаар уруудуулан дараалуулбал дараах байдалтай болж байна. Үүнд Бадарч (12), Итгэлт, Эрдэнэ (тус бүр 9), Даржаа баатар, Пүрэв тайж (тус бүр 6), анги Эрэнчин (5), Гэрэл, Чимэг (тус бүр 4), Төмөр, Галсан, Павлов, Түгжил, Бат, Магсаржав (тус бүр 3), Дорж, Дулмаа, Сүхбаатар, Ванданов (тус бүр 2) гэсэн дараалалтай байгаа бөгөөд үлдсэн баатрууд болох Должин, Долгор, Бадарчийн эхнэр, Довчин, Өлзий, Жамбал, Жаргал, Сүрэн, Солонго, Го Си-лин, Ням, хамба лам, худалдагч, шушмаа нар нэгжгээд уурлан бухимдсанаар уг романд дүрслэгджээ. Зохиолд уурлах үйлдэл нь ямар нэг байдлаар илэрхийлэгдсэн эдгээр баатрын уурлах үйлдлийн тоо нь нэгээс 12-ын хооронд хэлбэлзэх бөгөөд үүний тавин хувьд нь Бадарч, Итгэлт, Эрдэнэ, Даржаа баатар, Пүрэв тайж нарын уур бухимдлын тоо багтах тул энэ хэдэн баатрын тухайд холбогдох шинжийг бага зэрэг дэлгэрүүлэн үзэж болох юм. Ингээд энэхүү шинжийг уул романы онцгойрон дурдагдсан баатруудын өвөрмөц дүрийн жишээгээр тус бүрд нь дараах байдлаар товчоолон тодорхойлохыг оролдов. Үүнд:

Тахар Бадарч: Романд Бадарчийн *хөмсгөө сүртэй зангидах, уурлах, бухимдах (2), бүдүүн дуугаар зандрах, хорсон бухимдах, хорсох (2), шүд зуух, нүүр татганан чичрэх, шазуураа зуух, их омог нь бадрах* гэх мэтийн үг, хэллэг бүхий 12 удаагийн уур бухимдлын үйлдэл илэрсэн байна. Энэ хүний талаар романы эхэнд зохиогчоос тодорхойлон бичихдээ “... Арван долоон наснаасаа Лу гүний тамгын газар тахар хийсэн бөгөөд одоо гуч хүрчээ.

Хэрэгтэнд хатуу харгис, бас тэгээд чадал хүч ихтэй долоон хошууны заан цолтой хүн. Тахар хийснээс хойш хээл, хахууль авч овоо хөрөнгөтэй болоод сүүлийн үед хүнийг “Муу гуйлгачин” гэж дайрах нь улам олон болж байгаа билээ” (ТТ:25)³ гэсэн байна. Бадарч тахарын уур хилэн чухам ямар үед гарч ирдгийг зохиолын үйл явдал дундаас түүвэрлэн зарим нэг жишээгээр үзүүлбэл дараах байдалтай ажээ. Үүнд:

- Цахиур Төмөрийг банздан хэрэг хүлээлгэж чадаагүйдээ, бас түүнийг ширтэй нь оргуулан алдсан үедээ:

(1) Бадарч улам хорсож нэг банз хугалсан боловч Төмөр бахь байдгаараа нүдээ гөлийлгөн шүдээ хяхтнуулан хавирч байв.

- Чи чинь чулуу юм уу, хүн юм уу? гэж уурласан тахар асуухад Төмөр:

- Жа би хоёр хөлтэй, хохимой толгойтой хүн билээ гэж ёжлон хариулав (ТТ:26).

(2) Төмөрийг олох нь битгий хэл, мөр сураг гаргаж чадаагүйдээ Бадарч хорсон бухимдаж дайралдсан гэмгүй хүнийг хүртэл бүдүүн тэнзэн ташуураар ухаан алдтал нь занчиж явлаа (ТТ:42).

- “Бадарчийн нэг гол шинж нь шунахай. Шуналдаа хөтлөгдөхөөрөө юу ч хийхээс үл буцна. Тэрбээр Итгэлтэй нийлэн хошуу нутаг нь зудад нэрвэгдсэн тул тэдний нутагт малаа оторлож ирсэн Өөлд бэйсийн албат нарыг дээрэмдэж байдаг” (Ганбат Б. 1998:278).

Жишээлбэл:

(3) “Хүний нутагт зээр шиг дураараа сэлгүүцэж явдаг аль газрын цагаач вэ?” гэж Бадарч бүдүүн дуугаар зандран хэлэв.

- Бид Өөлд бэйсийн албат нар, зуданд хөөгдөөд явж байна гэж хүйтэн, нас хоёрт дарагдсан чавганц дорой дуугаар хариулав (ТТ:202).

- Хуучин засаг солигдож шинэ ардын засаг тогтоод Ардын засгийн анхны төлөөлөгчөөр Эрдэнэ томилогдон ирсэнд:

(4) - Итгэлт минь тэгээд тэр төлөөлөгч нь хэн гэж бодно. Санахаас бөөлжис хүрээд байна. Нөгөө танайд зарагдаж байсан гуйлгачин Эрдэнэ шүү гэж Бадарч “төлөөлөгч” “гуйлгачин” гэдэг үгийг шүд зуун хэлэв (ТТ:418).

(5) - Тийм ээ. Тэр муу цагаачин ноёны тамгыг хурааж авсан шүү гэхэд нь Бадарчийн нүд нүүр нь татганан чичирч байлаа (ТТ:418).

- “Охиноо Итгэлтийн бэр болгочих санаатай ёс алдан ам бузарласан удаатай” (Ганбат Б. 1998:278) бөгөөд ганц хүүдээ Ням өвгөний охиныг эхнэр болгохоор гуйж байгаа Итгэлтийг хараад:

(6) Энэ бүхнийг харсан Бадарчийн царай хар хүрэн болсноо шазуураа зуугаад эргэж явлаа (ТТ:449).

- Гамин цэрэгт нэр нүүр олох гэж очоод харин тэдэнд дээрэмдүүлэн явгараад:

(7) Бадарч эргэж гүйх гэтэл хүнд биеэ даасангүй шургачин унажээ. Шар цай ч ололгүй морьд, бөгжөө алдсандаа гол нь харлаж гамингуудад хорсон явжээ. . . Нойтон дээлэндээ дагжин чичирч, учирсан гарздаа бухимдан гэлдэрч явтал гурван морь хөтлөөд Өлзийнд очих, дараа нь Долгортой уулзах тэгээд уулзаж чадаагүй ганц ахынхаа мөрийг гаргах гэж явсан Төмөртэй яг дайралдав (ТТ:225).

Баян Итгэлт: Романд Итгэлтийн уурлах хилэгнэх байдлыг илэрхийлсэн *дуу шуугүй уурлах, уурлах* (3 удаа), *уцаарлах, бухимдах* (2 удаа), *уур бухимдлаа дарах, уур нь багтаж ядан бадрах* гэсэн үг, хэллэг бүхий 9 өгүүлэмж ил дүрслэгдэн бүртгэгдсэнээс гадна мэдээж

³ Лодойдамба Ч. *Тунгалаг Тамир*. XX зууны утга зохиолын дээж суварга-V. Уб., 2005, х. 559. Цаашид эл романаас холбогдох жишээг эшлэл авахдаа “Тунгалаг Тамир” гэдгийг ТТ гэж товчлон ард нь хуудасны дугаарыг бичиж тэмдэглэнэ.

шууд илрээгүй боловч өгүүлбэр, эхийн холбосон орчин, зохиолын үйл явдлын өрнөл, үйл явц, логик үргэлжлэлтэй холбоотой өөр бусад уурлах хилэгнэх үйлдэл олон удаа далд хэлбэржсэн нь ойлгомжтой юм. Тухайлбал, “Хөх булуу болтол нүдүүлсэн Итгэлт “муу цагаач чамайг хонгоны махыг чинь борви дээр чинь буулгана даа” гэж шүдээ хавиран явахад “тэнэг золигийн цус, нөжийг нь хутгах хэрэгтэй” гэж Галсан дуу нийлүүлж явлаа” (ТТ:182) гэсэн өгүүлбэрт Итгэлтийн уур омог нь дээд цэгтээ тулсан нь мэдээж юм. Энэ мэтийн далд өгүүлэмж романд олон удаа дүрслэгдсэн байх бөгөөд бид энэ удаа уурлах хилэгнэх үйлдэл илэрхийлсэн үгэн ба үгэн бус өгүүлэмж дотроос зөвхөн “уурлах” төвт үйл үгээр ил (эксплицит) хэлбэржсэн, уурлах утга санаа бүхий өгүүлбэрийг түүвэрлэн ажиглалт хийсэн билээ. Итгэлтийн хэв шинжит дүрийг түүний уурлах хилэгнэх зарим үйлдлээр нь шинжиж, чухам ямар үед, ямар учир шалтгааны улмаас уурласан болохыг байцаан үзвэл дараах дүр зураг ажиглагдаж байна. Үүнд:

- Ажилсаг хөдөлмөрч зан чанар нь бусад хүмүүсийн үйлдэлтэй зөрчилдвөл: Үнэхээр “Итгэлт үүрийн гэгээ цайхаас эхлээд үдшийн бүрэнхий болтол борви бохисхийхгүй юм хийж байдаг. Хавь ойрын хүмүүсээ ч яг тийм байлгахыг хичээдэг. Энэ ч учраас эхнэр Должин нь бусдаас түрүүнд босоод, бусдаас түрүүнд үнээгээ сааж билчээдэг заншилтай” (ТТ:20) болохоор

(8) Хэрэв аль нэгэн айлаас хожимдвол тэд өдөртөө дуу шуугүй уурлан явдаг. Энэ зангийг нь мэддэг зарц нар нь их гэрийн цайны уур дуугарахаас нааш босдоггүй (ТТ:20).

(9) “Ядахдаа хэдэн хамжлагаа ч зарж чадахгүй арчаагүй мөртлөө хортой, мунхаг мөртлөө шунамгай амьтан” гэж жигшин бухимдаж “хэрэв би хошуу толгойлж байсан сан бол эд нар шиг хөдлөх бүрдээ хятадын пүүсэнд нялх хүүхэд шиг мэхлүүлэн өр тавьж албан татвараар мань мэтийнхнийг чирэгдүүлж байхын оронд хошууны тоогоо алдсан гуйланчныг цуглуулж авчраад уяагийг нь уртхан уяж, угадсыг нь өтгөхөн шиг өгч байгаад цэмбэ нэхүүлэхгүй юу” гэж хүртэл бодож байсан билээ (ТТ:89).

- Өөрийнх нь хэлснээр “Тамирын голын мөсийг долоох шахам байж” насан туршдаа зовж зүдэн байж цуглуулж хураасан хөрөнгөө ардын засгийн үед хураалгаад:

(10) Хороос бусдаар хоол хийж, холтсоноос бусдаар эд хийж, хэмжээлшгүй хвч ухаан зарцуулан байж хуримталсан хөрөнгөө хураагдсанд Итгэлт үлэмж бухимдан, сэтгэл бодол нь хоосон хөндий болоод хүч чадал нь далавчаа огтлуулсан бүргэд шиг болжээ.

Өглөөнөөс эхлэн үдэш хүртэл ямар нэгэн юм хийж харласан сэтгэлээ зугаацуулан уур бухимдлаа дарж байлаа (ТТ:567).

- Хаяаг нь түшиж хар залуугаасаа зарагдан бас нөмөр нөөлөгт нь амьдарч явсан Галсан хожим ардын засгийн үед хамтралд элсэн ороод нэг удаа хөрөнгөө хураалгасан Итгэлтийнд ирж архины халуунд хөөрөн гашуун нясуун үг хэлж агсамнасанд:

(11) - Должин оо! Галсанд архи хийж өг гэж Итгэлтийн хэлэхэд нүдэнд нь хязгааргүй хорсол тодорч байлаа. Итгэлтийн уур багтан ядан бадарч Галсанг одоохон өшиглөөд хөөж гаргамаар байсан авч сэтгэлийн гүнд тэгж болохгүй, өнөөдөр Галсан үнэтэй болохоор хэрэгт амархан орно (ТТ:569).

- Залуу наснаасаа нууц амрагийн холбоотой явсан сайхан хүүхэн Дулмааг бусад эрчүүдтэй холбоотой болсныг нь мэдээд түүнийг хардаж:

(12) Итгэлт хардаж уурлаж байхад нь Дулмаа нэг талаар түүнийг чадаж байна гэж баярладаг боловч бас айж энэ хүний гараас нь сайнаар гарч чадахгүй гэж боддог байлаа (ТТ:61).

- Эхнэр нь өөрийг нь бусадтай хардаж үглэсэн, хүүхдүүд нь үгэнд нь орохгүй зөрүүдлэсэн зэрэгт түүний уур хүрсэн байна.

Хувьсгалч Эрдэнэ⁴: Романд Эрдэнийн уурлах хилэгнэх үйлдлийг илэрхийлсэн уур нь гэнэт буцлах, уур нь дэлбэрэн шатах, дотроо бухимдах, нүдэнд нь гуниг бухимдал тодорхой болох, бухимдах (3 удаа), жигшин занах, хорсон бухимдах гэсэн үг, хэллэг бүхий 9 өгүүлэмж дүрслэгдсэн байна. “Аймаг дамжин цагаачилж, айлд зарагдан доромжлууулж явсан Эрдэнэ хувьсгалт тэмцлийн ээдрээт бэрх замд орж нийгмийн ухамсар сууж, улс төрийн хувьд хатуужиж, үзэл санаа нь бүрэлдэн төлөвшиж, тулхтай хувьсгалч болтлоо өсөж. . . ” (Ганбат Б. 1998:246) дэвжсэн бөгөөд түүний энэхүү 9 удаагийн уур бухимдлын учир шалтгаан чухам юутай холбоотой байсныг дараах байдлаар товчоолж болох юм. Үүнд:

- Хоёр гамин цэрэгт баригдан чирэгдэж яваа нэгэн монгол эмэгтэйг гэнэт хараад:

(13) Эрдэнийн уур нь гэнэт буцалж шуугин очоод хүнд гараараа нэг нэг цохисон чинь хоёр цэрэг тонгорцоглон унаж, хүүхэн алга болов (ТТ:241).

- Бароны хоёр орос цэрэг балчир хүүхэдтэй нэг монгол хүнийг хүчээр дүүжлүүр рүү чирж явааг харангуутаа:

(14) Эрдэнийн уур дэлбэрэн шатаж бүсэндээ байсан сэлээдийг атган автал дэргэд нь ирсэн монгол цэрэг гарыг нь шүүрэн барьж аваад:

- Та болохгүй гэлээ (ТТ:252).

- Жасын хөрөнгөнөөс өлсөж ядарсан ард олонд тарааж өгснийхөө төлөө Цэцэрлэг мандлын аймгийн намын хорооны даргын албан тушаалаа өгч, хилс шийтгүүлсэн үедээ:

(15) “Би буруу юм хийгээгүй. Энэ засаг бол ард түмний төлөө засаг. Би цөөн жасыг хохируулж, өлсөж ядарсан олонд тус болсон. Энэ чинь ардын засгийн бодлогыг гуйвуулсан хэрэг гэж үү? Жас, хийд хөрөнгөтэй байсан цагт ардын төрд муу болохоос тус болохгүй” гэж бодоход хилс шийтгүүлэв гэж бухимдана (ТТ:549).

- Орос нутаг руугаа буцахаар болсон эрхэм нөхөр Петрт хөл залгуулах унаа олж өгч чадахгүйдээ өөрийгөө зэмлэн арга мухардаж:

(16) Урамгүй, газар ширтсээр Эрдэнэ гарч гэрийн зүг явахад ямар аргаар морь олж, Петрт хөл залгах тухай бодол сэтгэлийг эзэмдэж бодсон бүхэн нь мухардан арчаагүйдээ бухимдан байжээ (ТТ:109).

(17) Маргааш нь дэмий л бухимдан сэтгэлийн хар зовлон эдэлж байтал адуунаас тасарсан хоёр морийг эрэх ажилд оногдоод хагас өдөр явж баймааж олоод буцах замдаа хонь хариулж явсан Дулмаатай дайралдаж буугаад тамхи татаж суутал өндөр сайвар хар морьтой Бадарч ирлээ (ТТ:109).

- Итгэлтэд гэнэдэж ашиглагдсан эхнэр Долгорынхоо талаар харамсан бодож сэтгэлийн гүн хямралд орохдоо:

(18) Эрдэнэ богдын хүрээ чиглэн явах замдаа хамгийн дотно үнэнч гэж итгэж явсан Долгортоо ариун цагаан сэтгэл, гүн хайраа доромжлуулсандаа гомдон, амьд бүхнийг жигшин занаж байлаа (ТТ:191).

- Итгэлтийн малаа дарсан хэргийг шууд илчлэх баримт нотолгоо олж гаргаж чадаагүй болохоор:

(19) “Итгэлт чи л мал дараагүй байх даа. Нар баруун хойноос навгас нөмрөөд гарсан цагт чи тооноос мал дарахгүй болох байх. Сүрэн хэцүү гэж Батын ярьдаг ортой л юм байна” гэж Эрдэнэ дотроо бухимдавч тулгах баримт байсангүй (ТТ:526).

- Тухайн үеийн монголын нийгмийн шударга бус байдлыг бие, сэтгэлээрээ мэдэрсэн тул:

⁴ “Тунгалаг Тамир романы уран сайхны туршлагын зарим асуудал” сэдвээр хэл бичгийн ухааны доктор (Ph. D)-ын зэрэг хамгаалж, “Монголын сонгодог зохиолч Чадраабалын Лодойдамба” (амьдрал, уран бүтээл) хэмээх нэг сэдэвт зохиол туурвисан утга зохиол судлаач, зохиолч, доктор Б.Ганбатын гаргасан дүрийн тодорхойлолтыг энд хэрэглэсэн болно (Зох).

(20) Энэ бүхнийг бодоход ертөнцийг үнсэн товруу болгомоор санагдавч өшөөгөө авах чадалгүйдээ хорсон бухимдана (ТТ:191).

Даржаа баатар: Тэрбээр *хорсох, хуруугаа чичлэн дайрах, нударгаа шамлах, уурлах, бүдүүн боргил дуугаар гэнэт хашгирах, царай нь хүрэн болох* зэргээр уур бухимдлаа гаргахдаа “Чухам үнэн. Өвгөд дээдсийн онгон нутгийг хүний газар гэсэн булай бичигт гарын үсэг зурсан хүн бол өчүүхэн хэргэмээс үе улирах нэрээ худалдсан дамшиг”, “Та нар шиг өнөөдрийн өөхнөөс улс төрийг худалдахаас буцахгүй амьтад л дээдсийн толгойг эргүүлж байгаад тэр новшийн гэрээг байгуулж, түмэн балаг тарьсан хэрэг”, “Муусайн төрийн худалдаачин” гэх зэргээр хашгирах ажээ. Жишээлбэл:

(21) Хага базуулсан Юндэн хариу юу ч дуугарч чадсангүй минчийтэл улайгаад, хоолойнхоо товчийг тайлав. Гэрийн дотор хэсэг зуур нам гүм болов. Энэ нам гүмийн дотор Итгэлт шиг баярласан, Гэрэл шиг гомдсон, Даржаа шиг уурласан, гэрийн эзэн шиг ичсэн хүн байсангүй (ТТ:169).

(22) - Ер нь та нар олон аавын хүү цус урсгаж баймааж байгуулсан улс төрийг минь худалдаж орхиод гэмгүй хүн шиг гэлбэлзэж байна гэнээ гэж Даржаа бүдүүн боргил дуугаар гэнэт хашгирав (ТТ:169).

(23) -Мэргэдийн явдлыг мэргэд хэлэлцэнэ. Бид бичиг цэргийн түшмэд, амьтныг жаргуулагч бурхны хувилгаан, түмэн наст богд Жавзандамба нэгэнт хамт шийдсэн хэргийг. . . гэж Довчин хүйтэн бөгөөд тайван дуугаар эхэлтэл тэвчээр нь дууссан Даржаа “Дуугаа аяд. Бүү донгос” гээд царай нь хүрэн болон босов. Хэрэв гаднаас Богдын шадар сойвон Данигай орж ирээгүй бол Даржаа баатар Довчинг салам болтол нүдэж орхих байсан нь дамжиггүй (ТТ:170).

Пүрэв тайж: Хошуундаа нэр нөлөө муутай энэ тайжийн уурлан *догширох, нүд нь таталдан уурлах, уурлах, уур омог галд орсон дарь шиг оволзон асах, уур уцаар болох, бухимдах* гэх зэргээр дүрслэгдсэн нь бүгд дорд хамжлага нартаа сүрийг үзүүлж гаргасан уур уцаар ажээ. Жишээлбэл:

(24) Тайжийн нүүр нүд нь таталдан уурлаж бүдүүн тэнзэн ташуураар балбав. Энэ бүхнийг харсан Төмөр тэсэж чадсангүй шуугин очиж “хамжлагаа хазсан тайж, хаягаа хадарсан луйварчин гэгчээр энэ хүн өчүүхэн ч гэм хийгээгүй байхад та дэндүү хэрцгий байна” гэсэн чинь тайжийн уур омог галд орсон дарь шиг оволзон асаж “чи хаа газрын гуйланчин бэ? Сайд вангийн Пүрэв тайж авгаа танихгүй байна уу?” гээд ташуураа далайн ирлээ (ТТ:40).

(25) - Боол чи нохой аминдаа хайртай юм бол юу өгөхөө надад хэл гэхэд нь Өлзий хайнагийн үнээ нэг, сарлагийн үнээ хоёрыг өгье гэхэд нь тайж уурлаж илүү юм шаарджээ (ТТ:115).

Буриад Вандановын *бухимдан уурлах, хагартлаа уурлах* гэсэн хоёр үйлдэл тэмдэглэгдсэн бөгөөд энэ нь улаантны эсрэг үйл ажиллагаатай нь холбоотой юм. Жишээлбэл:

(26) Улиастайд Бароны тушаалаар урьд очсон Ванданов цагааны дарга нарын хамт монгол цэрэг дайчилж Зөвлөлт улс, Хиагтад буй болсон Монголын ардын түр засгийг эсэргүүцэх бэлтгэл хийж байжээ. Гэтэл татсан цэрэг нь оргож хүнс тэжээл агт морьд тасалдаж, ажил нь огт бүтэхгүй байлаа. Бухимдаж уурласан Ванданов, Улиастайн сайд Чүлтэмийг дуудав (ТТ:271).

- Би очиж чадахгүй. Дуртай бол ирж уулз гэж Вандановын элчид хариулжээ.

(27) Чүлтэмийн хариуг сонсоод Ванданов хагартлаа уурлаж “Чамд би хэн гэдгээ үзүүлье” гэж хашгирав. Орой нь цагааны арав гаруй дарга явуулж Чүлтэмийг барьж зайдан морь унуулан авчрав (ТТ:272).

Анги Эрэнчин зандран уцаарлах, уцаарлах (2), уцаар ууртай болох, бухимдах зэргээр уур бухимдлийн сэтгэлийн хөдөлгөөнөө илэрхийлэх бөгөөд энэ нь ихэвчлэн шавь нарынх нь үйлдэл сэтгэлд нь хүрэхгүй, орчин тойрных нь хүмүүс өөрт нь таалагдахгүй, тэрчлэн шашны номлол нь ахуй амьдралаас гажиж эцэст нь өөрөө өөртэйгээ зөрчилдсэнтэй хобоотой ажээ. Жишээлбэл:

(28) Нэгэн удаа Батыг дагуулан гадаалж явахад нь нэг авгай ирээд хайрцаг шүдэнз барьж ерөөл авах гэхэд “би ерөөл гэдэг юу юм бэ гэдгийг мэдэхгүй” гэж уцаарлан хэлжээ (ТТ:255).

(29) Эрэнчинг эрдэм ухаантай лам гэж олноор хэлэлцдэг. Гэтэл хийсэн юм гэвэл өдий төдий хүнийг өөр шигээ арчаагүй болгожээ. Энэ бүхнийг бодоход Эрэнчингийн сэтгэлийг ямар ч гэрэл гэгээгүй бухимдал эзлэв (ТТ:253).

Эрдэнийг гэсэн Гэрэлийн уур бухимдлын илрэлийг романд уурлах, догшин нүдээр ширвэж харах, хорсолтой бөгөөд жигшилтэйгээр чанга инээх, хавханд орсон чоно алахаар ирсэн хүнийг харж байгаа нүдээр ширтэх гэх зэргийн үг, хэллэгээр илэрхийлжээ.

(30) “Эхнэртээ хүүхэд шиг загнуулаад л өглөө бүхэн тантантай юм асгаж явах юм” гэж Довчингийн хэлэхэд өөр юм бодож байсан Гэрэл догшин нүдээр ширвэж харснаа “Юу гэнэ ээ чи” гэж асуухад нь “би бол хэрэлдэж, маргалдалгүй асгаж орхино” гэж нүдээ жартайлган инээмсэглэснийг зарц эмэгтэй нь сонсоод нэг хүнд хэлж орхисон нь тарж Хүрээнийхний ярьж инээдэг хошин яриа болжээ (ТТ:192).

(31) -Чиний хажууд хэлдэг чинь байхаас өөр хэн байх вэ. Янханд дарлуулж суусан хохь чинь гээд Гэрэл хорсолтой бөгөөд жигшилтэйгээр чанга инээв (ТТ:307).

Чимэг хүүхний уур бухимдал нь уцаарлах, ширвэх, царайнд түймэр шатах, багтран дуугүй болох гэх зэргийн үг, хэллэг бүхий өгүүлэмжээр илэрсэн байна. Жишээлбэл:

(32) Хоёр хүүхэнтэй дэмий балай шалиг юм ярьж марзаганах зуур арван мөнгөн янчаан гаргаж гүнгэрваатай богд ламын нь өмнөх ширээн дээр давхарлуулан тавиад ихэмсэг нүдээр Чимэг рүү харлаа.

- Арван муу янчаан тавьчихаад арван бөгтөр ембүү тавьсан юм шиг ханхалзаж байх шив дээ. Нохой долоож үх гээд Чимэг ширвэлээ (ТТ:120).

(33) Энэ Чимэг хүүхэн бузар самуун явдалтай болохоор манай намд байх гавьяагүй буюу. . . ” гэтэл Чимэг хүүхний царайд түймэр шатан ухасхийн босож нүдээ гялалзуулан хөмсгөө зангидан уруул нь чичирнэ (ТТ:443).

Цахиур Төмөр эхнэрээ өмөөрөн хамгаалж, бас эхнэр хүүхдээ санан санаа зовохдоо уур бухимдлаа илэрхийлсэн бөгөөд харин түүний уурыг бас нэг удаа хүргэсэн хүн бол Түгжил юм. Жишээлбэл:

(34) Адуу хөөн үргэлж холхин өргөн говийг огтлох тийм амар хэрэг биш. Аажмаар Түгжилийн баяр үгүй болж өлсөх, цангах, ядрахын туйлд хүрч, зогсож амрах тухай Төмөрт хэлсэнд “Балаг болж адууны хагасыг орхиулчихаад бас амрах санаатай, ямар дүүрчихсэн эр вэ” гэж хөмсгөө зангидан уурлажээ. Түгжилд дахиад хэлэх зүрх байсангүй (ТТ:101).

Хоёр Галсан гурван удаа уурлахдаа хоёрыг нь эхнэр Дулмаад, нэгийг нь баян Итгэлтэд гаргажээ. Жишээлбэл:

(35) -Гөвчихнө байгаа гэж айх заяа буян надад байхгүй гэж Дулмаа хөгжүүн инээмсэглэн хэлээд хаалгаа тас хийтэл хаяад гарлаа.

- Тэнэг гичий гэж Галсан хойноос нь хашгираад барьж ирсэн цардмал цуваа ор руугаа ууртай чулуудав (ТТ:23).

(36) Өнгөрсөн намар Галсангийн идшинд хөл нь хугарч хатсан туранхай сарлаг өгөхөд нь Дулмаа “Энэ дэвхрэг Итгэлт, хоёулыг минь зарж байгаа мөртлөө үзэх өөхгүй хатингар зовлого өгнө гэнээ” гэсэнд Галсан уурлаж “Хар эм чи, буянг нь гударч байгаад эзнийг

нь муу хэлнэ гэнэ ээ. Задарсан өлөгчин” гэж хэлээд эр эм хоёр хэрэлдэж, эцэст нь Дулмаагийн нүдийг золтсоор хөхөртөл цохижээ (ТТ:54).

Цагаан Павловын уурлах байдлыг *бухимдан муухай хашгирах, шүдээ зуун хорсох, хөөс сахруулан агсрах* гэх зэргээр дүрслэн үзүүлсэн бөгөөд түүний уурлан бухимдахын шалтгаан нь улаан орос болон гамин цэрэг юм. Жишээлбэл:

(37) Тэр шөнө хоёр найз архи ууж ярихад Павлов согтож пад пад хийтэл ширээ шааж өөрсдөө юу ч хийж чадахгүй байж хүний буяныг булаасан зэрлэг хүмүүсийг элдвийн үгээр занан өшөө авна гэж ярив.

Заримдаа бухимдан муухай хашгирч, оросоор аль муухай хараалыг урсгаж байлаа (ТТ:217).

(38) - Өвгөн чинь ч бас балраад байна. Байдаг хэдийгээ гаминд идүүлж орхисон гэж Итгэлт гашуудалтай хэлжээ.

-Хаа байна. Тэр гамингийн хавнууд, бид тэднийг дэвсэж орхиё. Үнэн шүү Итгэлт минь. Бид дэвсчихнэ гэж Павлов завьжаараа хөөс сахруулан агсрав (ТТ:245).

Хулгайч Түгжилийн уур бухимдалтай холбоотой *дотроо бухимдах, уур нь хүрч бачимдах, бухимдан уур нь хүрэх* үйлдлийн учир шалтгаан нь дараах өгүүлэмжийн санаанаас тодорхой харагдаж байна. Жишээлбэл:

(39) Харин Төмөр дөрөөн дээрээ босож зогсоод “Эрдэнэ засгийн унага”-аа шуранхайлан дуулж явахад Түгжилийн уур хүрч, бачимдавч яах ч аргагүй байлаа. Гуравдахь өдрийн орой жижигхэн задгай булаг дээр очиж морьдоо услав (ТТ:97).

(40) - Говь огтолж гарахдаа булаад эргэж ирэхдээ ууна гээд мордоход Түгжил дуртай, дургүй мордлоо. Тэр бүх бие нь няцран өвдөж “Юунд энэ солигтой нийлэв дээ” гэж бодон дотроо бухимдана (ТТ:98).

(41) “Халхын гуйлгачинг тэжээж барах юм уу?” гэж Түгжил бодоод бухимдан уур нь хүрсэн боловч Төмөрт хэлж яахин чадах билээ (ТТ:101-102).

Сэхээтэн Батын уур бухимдал нь “Гайгүй дээ эндээс нэг гарсан цагт” хэмээн өөрийг нь сэлэм эргүүлэн цавчдаг гэж худал ярьж байгаа Жаргалд бухимдсан бол “Ямар ч тус болохгүй. Богдоосоо аваад цөм яргачин, мөнгө өгөөд л гэмгүй сайн хүнийг алдаг юм. Нүгэл гэж яривал тэд л хийдэг” гэж анги Эрэнчин багшийг нь хороолгосон Богдод “*нүдээ хорсол жигшлийн галаар эргэлдүүлэн*” уурласан бөгөөд бас хадам эцэг Итгэлтэй зөрчилдөн “*царай минчийн улайх*” байдлаар уур бухимдал нь илэрчээ. Жишээлбэл:

(42) Энэ бодол нь буглаж дэлбэрэх болсон үед Хонгор хатирт шаргыг Батад барьж өгсөн билээ. Бат тэвчиж чадалгүй Итгэлтэд хариу үг хэлсэн бол хэрүүл гарах нь дамжиггүй байсан. Батын царай минчийн улайрч Итгэлтийг шүд зуун харснаа Галсангийн уургалсан бор үрээг чихдэн хазаарлаж аваад Хонгортой нийлэн эмээллэв (ТТ:511).

Эх оронч Хатанбаатар Магсаржав “Эднийг (ширээний хоёр хүүхэн - Д.О) гаргахгүй бол би тантай нэг ч үг солихгүй” гэж Хятадын генерал Го Си-линд, “төрөлх нутгаасаа хөөгдөж ирээд төрсөн нутагтаа байгаа хүнийг дуудна гэнэ” хэмээн Оросын цагаан цэргийн буриад офицер Ванданов нарт тус тус уураа гаргасан бөгөөд бас *савхаа өмнөх ширээн дээр тас хийтэл тавих* байдлаар уур бухимдлаа илэрхийлсэн байв. Жишээлбэл:

(43) - Та баахан сархад зооглосноос болж түүх судраа мартаж байгаа бололтой. Бид төр хамтран байгуулж байсан удаагүй. Харин нэгэн нь хүчирхийлж, нөгөө нь дарагдан захирагдаж байсан. Сүүлдээ хоёул Манжийн эрхэнд орж дарлагдан байсаар эцэст хоёул тусгаар улс болсон. Гэтэл та нар цэргийн хүчээр түрж биднийг эзэлсэн билээ. Гэвч эзлэгдэх, дарагдах хоёр шал өөр зүйл болохоор бид эзлэгдсэн боловч дарагдаагүй байгааг эрхэм жанжин ойлговол зүгээр юм даа гээд Магсаржав савхаа өмнөх ширээн дээр тас хийтэл тавив (ТТ:264).

“Улаан хувьсгалч” Доржийн учиргүй уурлах, муухай үгээр зүхэх үйлдэл нь хувьсгалын үйл хэрэгтэй холбоотой байлаа. Жишээлбэл:

(44) Ялангуяа хоршооноос бярдан бууны сум хайрцгаар авсан нэг хүн саяхан хар болсон лам байсныг мэдсэнээс хойш тун сэрэмжтэй болж хэн нэгэн хүнд сум, дарийг их хэмжээгээр хамаагүй худалдахаа зогсоохыг худалдагчид нь зөвлөжээ. Гэтэл үүнийг нь Дорж мэдээд учиргүй уурлан “Ард түмнийг хардаж байгаа” Эрдэнийн зан байдлыг намын үүрийн ойрын хурлаар авч хэлэлцэх болсон юм (ТТ:597).

Сайхан Дулмаагийн уур бухимдал хамгийн их хүчтэй илэрсэн хэсэг нь Эрдэнэтэй холбоотой бөгөөд түүний нүд нь галзуу үхрийн нүд шиг гөлрөн зангирч хөмхийгөө зуух, хорсолтой нүдээр харах зэргээр уурласан сэтгэлийн байдлаа илэрхийлжээ. Жишээлбэл:

(45) - Ёсолж авсан эр нөхөртэй байж тэр асман ламтай юу болоод байдаг юм бэ? Хүнд чинь ёс дэглэм гэж байдаг юм шүү гэж Эрдэнийн хэлэхэд Дулмаагийн нүд нь галзуу үхрийн нүд шиг гөлрөн зангирч, барьж байсан шилбүүрээ газар шидэж, хөмхийгөө зуун ойртож ирснээ:

- Өөрийнхөө эхнэрийг захирч байгаад намайг захираарай гээд шууд эргэжээ (ТТ:181).

Жанжин Сүхбаатарын хөмсөг нь зангирах, хөмсөг нь мушгиран эрчлэх байдлаар илэрсэн уур бухимдал нь зөвхөн ардын хувьсгалын үйл хэрэгтэй холбоотой байна. Жишээлбэл:

(46) Маргааш өглөө нь Доржийн тавьтыг жагсаав. Хэдэн хүний хамт Сүхбаатар давхиж ирээд мориноос бууж хөмсөг нь мушгиран эрчилснээ: “Та нар бол ардын журамт цэрэг болохоос биш, бүлэг дээрэмчид биш. Өчигдөр орой пүүснээс дээрэмдсэн юмаа одоо энд авчирч тавь” гэлээ (ТТ:288).

Ийнхүү “Тунгалаг Тамир” романы баатруудын уурлан хилэгнэх байдлыг уул зохиолын үйл явдлын эхлэл, өрнөл, туйл, тайлал, төгсгөл дунд нь, тэдний дүрийн өсөлт бойжилт, хөгжил төгөлдөржилтийн зүй зохист логик харьцаа хамаарал дотор нь товч боловч тодорхойлон үзүүлбэл ийм ажээ.

Зохиолын баатруудын уурлах хилэгнэх энэхүү байдлыг тухайн дүрийн өвөрмөц, хэв шинжит онцлогтой нь холбон, улмаар уурлан бухимдах болсон шалтгаан нөхцөлтэй нь уялдуулан авч үзсэн дээрх ажиглалт дээрээ тулгуурлан ерөөсөө уурлах хэлэхүйн үйлдлийн илрэх хэл зүйн загварыг бүртгэн гаргах нь сонирхолтой байж болох талтай гэж үзлээ. Энэ зорилгын үүднээс дараах хэдэн загварыг товчоолон гаргав. Үүнд:

- Үйл үгийн үндэс + н + уурла-. Жишээлбэл: *бухимдан уурлах, хардан уурлах* гэх мэт.

- Үйл үгийн үндэс + тал⁴ + уурла-. Жишээлбэл: *хагартлаа уурлах* гэх мэт.

- Нэр үгийн үндэс + тай³ + уурла-. Жишээлбэл: *дуу шуугүй уурлах, учиргүй уурлах* гэх мэт.

- Хэллэг + уурла-. Жишээлбэл: *нүд нь таталдан уурлах, хөмсгөө зангидан уурлах* гэх мэт.

- Уур + үйл үг. Жишээлбэл: *уур нь багтаж ядан бадрах, уур нь гэнэт буцлах, уур нь дэлбэрэн шатах, уур уцаар болох, уур бухимдлаа дарах, уур нь хүрч бачимдах* гэх мэт.

- Зохиогчийн хэрэглэсэн оновчтой хэллэг. Жишээлбэл: *уур омог галд орсон дарь шиг оволзон асах, их омог нь бадрах, бухимдлын бөглөө нь сулрах* гэх мэт.

Тэрчлэн уурлан хилэгнэх үед хүний нүүр царайны хувирал (мимика) хамгийн ихээр өөрчлөгдөн мэдрэгддэг байна. Жишээлбэл: *царайнд түймэр шатах, царай минчийн улайх, царай нь хүрэн болох* гэх мэт.

Мөн нүүр царайны бусад эрхтэн болох нүд, хөмсөг, хөмхий, шазуур, шүд зэрэг эрхтний хөдөлгөөн, хувирал өөрчлөлтөөр уур хилэнг илүү хүчтэй илэрхийлсэн байна. Жишээлбэл:

Хөмсөг: *хөмсгөө сүртэй зангидах, хөмсөг нь зангирах, хөмсөг нь мушгиран эрчлэх* гэх мэт.

Хөмхий: *хөмхийгөө* зуух гэх мэт.

Шүд: *шүд* зуух, *шүдээ* зуун хорсох гэх мэт.

Нүд: *хорсолтой* нүдээр харах, *нүд нь хорсол жигшилийн галаар эргэлдэх, хавханд орсон чоно алахаар ирсэн хүнийг харж байгаа* нүдээр ширтэх, *догшин* нүдээр ширвээж харах, *ширвэх*, *нүдэнд нь гуниг бухимдал тодорхой* гэх мэт.

Шазуур: *шазуураа* зуух гэх мэт.

Бас дуу авиагаар давхар илэрхийлдэг байна. Жишээлбэл: *бүдүүн дуугаар зандрах, хашиграх, бүдүүн боргил дуугаар гэнэт хашиграх, бухимдан муухай хашиграх, зандран уцаарлах, муухай үгээр зүхэх* гэх мэт.

Нүүр царайны өөрчлөлт хувиралтын зэрэгцээ дохио зангаа (жест) болон биеийн төрх байдал (поза) их үүрэгтэй байдаг байна. Жишээлбэл: *хөөс сахруулан агсрах, багтран дуугүй болох, хуруугаа чичлэн дайрах, нударгаа шамлах, савхаа өмнөх ширээн дээр тас хийтэл тавих, мөрөө угз татан огцом эргэх, хорсолтой бөгөөд жигшилтэйгээр чанга инээх* гэх мэт.

Романд “уурлах” төвт утга зүйн оронд ойролцоогоор хамаарах үгсийн дотроос уурлах (16), бухимдах (13), уцаарлах (4) зэрэг үг тодорхой давтамжтай орж, хилэгнэх, уурсах зэрэг үг төдийлэн хэрэглэгдээгүй бол харин хорсох, жигших, зангах, зэвүүцэх гэх мэтийн үг уурлах хэлэхүйн үйлдэл заасан утгаар идэвхтэй хэрэглэгдсэн байна.

Дүгнэлт

Орчин цагийн монгол хэлний хэлэхүйн үйлдлийн тодорхой хэв маягуудад тусгайлан чиглүүлж хийсэн цуврал судалгааныхаа хүрээнд бид “Тунгалаг Тамир” романы⁵ баатруудын инээх инээмсэглэх, уйлах уярах болон уурлах хилэгнэх үйлдлийн талаар хийсэн ажиглалт туршилтдаа үндэслэн дараах хэдэн зүйлийг эмхлэн хэлж болох юм гэж үзлээ. Үүнд:

- Энэхүү романы баатруудын хэв шинжит дүр нь инээх инээмсэглэх, уйлах уярах, уурлах хилэгнэх гэсэн гурван хэлэхүйн үйлдлийн хүрээнд ч гэсэн өөр хоорондоо ялгарч байна. Үүнийг зарим баатруудын тодорхой үйлдлээр харьцуулан үзүүлж болно. Үүнд:

- Баян Итгэлт 45 удаа инээж, 9 удаа уурлаж, харин нэг ч удаа уйлаагүй байна.
- Тахар Бадарч 20 удаа инээж, 12 удаа уурлаж, нэг удаа уйлсан байна.
- Цахиур Төмөр 17 удаа инээж, 3 удаа уурлаж, 3 удаа далд уйлсан байна.
- Хувьсгалч Эрдэнэ 15 удаа инээж, 9 удаа уурлаж, 2 удаа далд уйлсан байна.
- Сайхан Дулмаа 15 удаа уйлж, 10 удаа инээж, 2 удаа уурласан байна.
- Төөрч будилсан Хонгор 10 удаа инээж, 7 удаа уйлж, харин нэг ч удаа уурлаагүй байна.
- Үнэнч Долгор 14 удаа уйлж, 1 удаа уурлаж, харин нэг ч удаа инээгээгүй байна.
- Цагаан Павлов 5 удаа инээж, 3 удаа уурлаж, 2 удаа уйлсан байна.
- Жанжин Сүхбаатар 17 удаа инээж, 2 удаа уурлаж, харин нэг ч удаа уйлаагүй байна.
- Эрдэнийг гэсэн Гэрэл 4 удаа уурлаж, 3 удаа уйлж, 2 удаа инээсэн байна.
- Алиа Петр 19 удаа инээж, нэг ч удаа уйлж, уурлаагүй байна.
- Эх оронч Магсаржав 10 удаа инээж, 3 удаа уурлаж, харин нэг ч удаа уйлаагүй байна.

⁵ Ташрамд дурдахад “Тунгалаг Тамир” романы хэрэглэгдэхүүнд тулгуурласан дагнасан судалгаа сүүлийн үед өргөжих хандлагатай болж байгааг дараах бүтээлээр жишээлэн харж болно. Үүнд: Байган. “Тунгалаг Тамир” романы “нүд”- ний дүрслэлийн тухай. ЭШБ МХСС. МУИС. Уб., 2004. №23 (328), х. 197-202; Ким Ын Жөн. “Тунгалаг Тамир” романы солонгос орчуулга дахь монгол хэлний нийлэмж үгийн ажиглалт. (“*손/гар*” хэмээх үгийн жишээгээр). (Жич: Тус сэтгүүлийн гарчигт Монгол, солонгос хэлний нийлэмж үгийн харьцуулсан судалгаа (“Тунгалаг Тамир” романы жишээгээр) гэжээ). Хэрэглээний хэл шинжлэл. Боть III (18). Уб., 2018, х. 151-159; Уугансүрэн Д. Ч.Лодойдамбын “Тунгалаг Тамир” романы тогтвортой нийлэмжийг чех орчуулгатай нь харьцуулсан судалгаа. Оюутны эрдэм шинжилгээний бүтээлийн эмхэтгэл. МУИС. Уб., 2006. №9 (17), х. 66-73.

- Анги Эрэнчин 5 удаа инээж, 5 удаа уурлаж, харин нэг ч удаа уйлаагүй байна.
- Сэхээтэн Бат 13 удаа уйлж, 8 удаа инээж, 3 удаа уурласан байна.
- Хоёр Галсан 6 удаа инээж, 3 удаа уурлаж, 1 удаа уйлсан байна.
- Гэмгүй Ням 6 удаа инээж, 4 удаа уйлж, 1 удаа уурласан байна.
- “Улаан хувьсгалч Дорж” 3 удаа инээж, 2 удаа уурлаж, харин нэг ч удаа уйлаагүй байна.
- Бэйс Довчин 4 удаа инээж, 1 удаа уурлаж, харин нэг ч удаа уйлаагүй байна.
- Хулгайч Түгжил 6 удаа инээж, 3 удаа уурлаж, харин нэг ч удаа уйлаагүй байна.
- “Таван амт Сүрэн” 5 удаа уйлж, 3 удаа инээж, 1 удаа уурласан байна.
- Пүрэв тайж 6 удаа уурлаж, 5 удаа инээж, харин нэг ч удаа уйлаагүй байна.

Эдгээр 21 дүрийн дурдсан 3 үйлдлийг дахин хураангуйлж үзвэл:

- Долгорын ганцаараа баярлан инээсэн үйлдэл дүрслэгдсэнгүй.
- Итгэлт, Сүхбаатар, Магсаржав, Эрэнчин, Дорж, Довчин, Түгжил, Пүрэв тайж, Петр нарт уйлах шалтгаан нөхцөл гараагүй байна.
- Хонгор, Петр хоёр уурлаж бухимдсангүй ажээ.
- Бадарч тахар хамгийн олон удаа уурлан бухимдсанаар романд дүрслэгдсэн нь түүний төрөлхийн хүмүүжил, эрхэлдэг ажил болон зан төлөвийнх нь онцлогтой холбоотой юм.
- Долгор хамгийн олон удаа уйлж бухимдсан нь түүний туулж өнгөрүүлсэн амьдралын байдлаас нь шалтгаалсан байна.
- Итгэлт хамгийн олон удаа инээж баяссан нь түүний амьдралын байдалтай нь холбон тайлбарлагдах зүйл юм.

ELUCIDATING LITERARY IMAGERY BASED ON THE SPEECH ACT OF ANGER

(based on examples from Ch. Lodoidamba's *Tungalag Tamir*)

This article, a continuation of the author's research on such certain speech acts like smiling and crying in Mongolian, examines the typological features of lexical and non-lexical means of expressing the speech act of anger as exhibited by the main protagonists of *Tungalag Tamir* (*The Clear Tamir*) by Ч. Лодойдамба, a work forever immortalized as the most famous novel of modern Mongolian literature. Specifically, this article identifies verbal and non-verbal instances of the verb *uurla*- ‘to be angry’ and its synonyms, as well as instances of laughter and cry in this famous novel.

Examining the instances of anger of the protagonists of the novel *Tungalag Tamir* and their logical relations and the development of the characters as exhibited in the beginning, plot, conflict, resolution, and ending of the novel, can be analyzed as follows:

Connecting instances of the protagonists' anger with their specific character traits and typological features, as well as with the reasons for their anger, reveals the following interesting grammatical patterns:

- Verbal root + *-n* + *uurla*- as in: *buximdan uurlax* and *xardan uurlax*.
- Verbal root + *-tal* + *uurla*- as in: *xagartlaa uurlax*.
- Noun root + *-tai* + *uurla*- as in: *duu šuugüi uurlax* and *učirgüi uurlax*.
- Phrase + *uurla*- as in: *nüd n' tataldan uurlax* and *xömsgöö zangidan uurlax*.
- *Uur* + verb as in: *uur n' bagtaj yadan badrax*; *uur n' genet buclax*; *uur n' delberen šatax*; *uur ucaar bolox*; *uur buximdlaa darax*; and *uur n' xürč bačimdx* etc.

- Other specific phrases used by the author, such as: *uur omog gald orson dar' šig owolzon asax; ix omog n' badrax; buximdlîn böglöö n' sulrax* etc.

When one is angry, the most noticeable changes are the changes in their face. For example, *caraid tüimer garax; carai minčiin ulaix; carai n' xüren bolox* etc.

In addition to the face, the movement and changes of other body parts—such as the eyes, eyebrows, lower lips, and teeth—also strongly express anger. For example, eyebrows: *xömsgöö sürtei zangidax; xömsög n' zangirax; xömsög n' mušgiran erčlex* etc;

lower lips: *xömxiiгөө zuux* etc. ;

teeth: *šüd zuux; šüdee zuun xorsox* etc. ;

eyes: *xorsoltoi nüdeer xarax; nüd n' xorsol jigšliin galaar ergeldex; xawxand orson čono alaxaar irsen xüniig xarj baigaa nüdeer širtex; dogšin nüdeer širwej xarax, širwex; nüdend n' gunig buximal todorxoi* etc. ;

lower lips and lower teeth: *šazuuraa zuux* etc.

It can also be expressed with one's voice and speech sounds. For example: *büdüün duugaar zandrax; xašgirax; büdüün borgil duugaar genet xašgirax; buximdan muuxai xašgirax; zandran ucaarlax; muuxai ügeer züxex* etc.

In addition to changes in one's face, gestures and the poses of one's body also function to express emotions. For example: *xöös saxruulan agsrax; bagtran duugüi bolox; xuruugaa čičlen dairax; nudargaa šamlax; sawxaa ömnöx šireen deer tas xiitel tawix; mörөө ugз tatan ogcom ergex; xorsoltoi böгөөд jigšilteigeer čanga ineex* etc.

In the novel, the verb *uurla-* 'to be angry' and its near-synonyms appear with the following frequencies: *uurlax* (16 times), *buximdax* (13 times), *ucaarlax* (4 times). In the novel, these words express not only anger but are also actively used to denote other anger-related speech acts such as resent, disgust, loathing, scolding, and abhorrence.

Within the sphere of our series of research on the specific forms of modern Mongolian speech acts, we have examined the instances of smiling and laughter, crying, and anger as expressed by the main characters of the novel *Tungalag Tamir*, arriving at the specific conclusions in terms of their expression of these emotions.

Keywords: хэлэхүйн үйлдэл (speech act), утга зүйн орон (semantic field), уран сайхны дүр (literary image), хэв шинжит дүр (typological image), задлаг хам бүтэц (analytic constructions).

Номзүй

Болд Л. (Ерөнхий редактор) *Монгол хэлний дэлгэрэнгүй тайлбар* толь. 5 боть. Уб., 2008. “Бемби сан” хэвлэх үйлдвэр. XXXX+3278+IX х.

Ганбат Б. *Монголын сонгодог зохиолч Чадраабалын Лодойдамба (амьдрал, уран бүтээл)*. Уб., 1998, 318 х.

Дамбажав И., Алтан-Од Д. Солонго Д. *Оюун билгийн мэлмийг нээгч аялгуу сайхан монгол үгийн дээж*. Монгол хэлний дэлгэрэнгүй тайлбар толь бичиг. I боть. А- ОЮУТАН. XII+3-1212 тал. II боть. Ө-ЯШИН. Уб., 2006. “Өнгөт хэвлэл” ХХК. VI+3-1239 х.

Одонтор Ш., Батгөгс М. *Монгол хэлний гучтын тайлбар толь*. Боть I (А-О), Боть II (П-Я). Уб., 2013, 502 х.

Отгонцэцэг Д. 2014. *Монгол хэлэнд инээх үйлдэл илэрхийлэх нь*. Monggolhak 몽골학 (Mongolian Studies). Journal of The Korean Association for Mongolian Studies. Seoul, Vol. 38, pp. 159-179

- Отгонцэцэг Д.** 2015. *Инээх үйлдэл зохиолын баатрын хэв шинжийг илэрхийлэх нь (Ч.Лодойдамбын “Тунгалаг Тамир” романы Итгэлтийн инээх үйлдлийн жишээгээр).* Лавай. №12. ЭШБ МУБИС. Уб., х. 105-115.
- Отгонцэцэг Д.** 2016. *Зохиолын баатрын хэв шинжийг инээх үйлдлээр илэрхийлэх нь (Ч.Лодойдамбын “Тунгалаг Тамир” романы зарим дүрийн инээх үйлдлийн жишээгээр).* Monggolhak 몽골학 (Mongolian Studies). Journal of The Korean Association for Mongolian Studies. Seoul, Vol. 44, pp. 141-160.
- Отгонцэцэг Д.** 2017. *Монгол хэлний “инээх” үгт зүйр цэцэн үгийн талаарх зарим ажиглалт.* Лавай. №18. ЭШБ МУБИС. Уб., х. 112-118.
- Отгонцэцэг Д.** 2019. *Зохиолын дүрийн хэв шинжийг уйлах уярах үйлдэлтэй холбох нь (Ч.Лодойдамбын “Тунгалаг Тамир” романы баатруудын жишээгээр).* Monggolhak 몽골학 (Mongolian Studies). Journal of The Korean Association for Mongolian Studies. Seoul, Vol. 59, pp. 137-168.
- Отгонцэцэг Д.** 2019. *Монгол хэлний инээх инээмсэглэх үйлдэл заасан үйл үгийн үүрэг-утга зүйн онцлог.* (Хэвлэлд).
- Сумьяабаатар Б.** 2003. *Гучинзургаат тайлбар толь* (The Mongolian Explanatory Dictionary in 36 volumes). VI боть. Уб.,
- Цэвэл Я.** 1966. *Монгол хэлний товч тайлбар толь.* Уб.
- Цэвэл Я.** *Монгол хэлний товч тайлбар толь.* Нэмж дэлгэрүүлсэн хоёрдугаар хэвлэл. Үг, утга, жишээ, тайлбар, хавсралт тэргүүтнийг нэмж хянасан Ц.Шагдарсүрэн. Уб., 2013. XXII+1311 х.